

РУБРИКИЙН ҮНЭЛГЭЭГ ТУРШСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Б.Мөнхтуяа*, МУБИС

Abstract

This workshop is to improve school effectiveness and promote individual creativity; moreover to increase active participation, student motivation and interest. While implementing a rubric assessment the study will reach to the definite result of the pilot training. Rubric scale is a tool to help assess the knowledge, skills, and attitudes of students. Moreover, rubric helps students define their levels and achieve better results. Rubric helps students to obtain a certain level of results or points. There are many types of rubric scales, more specifically, we chose “process rubric”, because implementation and results are counted. Rubric assessment provides teachers with detailed indicators of individual performances, such as teamwork and leadership. Study notes are used to provide points in performance, development, and trends. In order to define the results of the workshop, we will incorporate process rubric, which we hope to evaluate if the workshop positively influence on the attitudes of students and if we achieve our outcomes. Moreover, teachers will be able to develop the self-selection criteria of rubrics and to utilize it based on their evaluation.

Түлхүүр үг

Хэмжээс, дүгнэхүй, үнэлгээ, туршилт, ахиц, үр дүн, рубрик

Удиртгал

Сургалтын эцсийн үр дүн нь суралцагчдын мэдлэг, чадвар эзэмшилт, хөгжил төлөвшилтөөр тодорхойлогдоно. Үүнийг үнэлж дүгнэх нь сургалтын үйл явцын нэг хэсэг төдийгүй технологийн үндсэн элементүүдийн нэг юм.

Хүснэгт 1

Үнэлгээний объект

Мэдлэг	Ухагдахуун, тодорхойлолт, томъёо, дүрэм Зарчим, онол, хууль, зүй тогтол гэх мэт
Чадвар	Унших, найруулан бичих, тэмдэглэл хийх, тодорхойлолт өгөх, санаагаа ойлгомжтой ярих, нотлох, ажиглах, харьцуулан жиших Задлан шинжлэх, ангилан бүлэглэх, ерөнхийлөн дүгнэх гэх мэт үйлдлийг бие даан ухамсартай хийх
Төлөвшил	Бие хүний эрхэм чанарыг үнэлнэ. Хичээл зүтгэл, өөрийгөө дайчлах, хичээнгүй нямбай, хариуцлагатай, бие даасан, бусдыг хүндлэх хайрлах, хамтач, тусч, хөдөлмөрч, эелдэг даруу, үнэнч шударга, ухаалаг шийдвэр гаргах зэрэг зан үйл (Ичинхорлоо, 2011.х.153)

Тэгвэл, үнэлгээний олон төрөл хэлбэрүүд дотроос “Рубрикийн үнэлгээ” нь суралцагчдын мэдлэг, чадвар, төлөвшлийг үнэлэх боломжтой хэлбэр гэж үзэж байна.

Рубрик нь хүссэн үр дүнд хүрэхийн тулд суралцагчийн эзэмших ёстой мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлсон жагсаалт юм.

Үүнд:

- Ихэнх рубрик нь суралцагч тодорхой түвшний дүн эсвэл оноо авахын тулд эзэмшсэн байх мэдлэг, чадвар, хандлагын чанарын түвшинг үзүүлдэг.
- Рубрик нь шалгуурт баримжаалсан байдаг.
- Хамгийн багадаа 3 түвшинг тодорхойлсон байдаг ба түвшин бүр багц шалгууртай байна.
- Сургалтын эхэнд рубрикийг суралцагчдад танилцуулсан байх шаардлагатай.
- Рубрик нь суралцагчдад суралцах үйлийг төлөвлөхөд нь хөшүүрэг болдог.

Рубрикийн төрөл

- Аналитик рубрик: Гарах үр дүн болон үйл явцын хэсэг тус бүр олон хяналтын жагсаалттай байдаг.
- Холистик рубрик: Энэ нь олон үр дүн бүхий параграфтай ижилхэн.
- Хяналтын жагсаалт: Энэ нь тийм, үгүй гэсэн шийдэлтэй, оноожуулсан хяналтын жагсаалттай.
- Дараалсан рубрик: Суралцагчийн ахиц дэвшлийг тасралтгүй тэмдэглэж байхад хамгийн тохиромжтой үнэлгээний хэлбэр

*✉ munhtuya_ba65@yahoo.com

юм. Энэ нь үе, үг уншиж сурах, тоо бодож сурах, чанга дуугаар уншиж сурах чадвар дадал эзэмшүүлэхэд тэмдэглэл хөтлөхөд хэрэглэж болно.

- Урт хэмжээтэй рубрик: Энэ нь урт хугацааны ахиц дэвшлийн рубрик юм. Дараалсан рубрик нь сургалтын нэг л үр дүн рүү чиглэдэг бол урт хэмжээтэй рубрик нь олон үр дүнгийн шалгуурыг багтаасан байдаг. Тодорхой нэг төсөл, хичээл болон нэг ангийн суралцагчдын үзүүлэх хэд хэдэн үр дүнг багтааж байдаг.
- Үйл явцын рубрик: Энэ рубрик нь багш нар суралцагчдадаа эзэмшүүлэхийг хүсдэг хамтран суралцах, манлайлал гэх мэт хувь хүмүүсийн харилцааны нарийвчилсан үзүүлэлтүүдийг багтаасан байдаг. Суралцагчдын тайлбар, гүйцэтгэл, төлөвшил болон хандлагыг оноожуулахад хэрэглэгддэг.
- Бүтээгдэхүүний рубрик: Энэ рубрик нь эцсийн бүтээгдэхүүний нарийвчилсан үзүүлэлтүүдийг багтаадаг. Бичил судалгааны ажил, илтгэл, реферат, бүтээлийн сан зэргийг оноожуулахад хэрэглэж болно.

Үндсэн хэсэг

Манай уламжлалт сургалтад суралцагчдын мэдлэг, чадварыг үнэлэхийг чухалчилж ирсэн. Гэтэл, өнөөгийн сургалтын зорилго нь их юм мэддэг болгох нь чухал биш, ажиллаж амьдрах ухаантай болгоход чиглэж байгаа тул сурах ерөнхий арга барил, хандлагыг зөв төлөвшүүлэхэд үнэлгээ чухал үүрэгтэйг анхаарах шаардлагатай юм.

Нөгөө талаар, үнэлгээг зөвхөн багш өгдөг, багш биднийг үнэлэх ёстой гэсэн өрөөсгөл үзэл бодлыг шинэчилж өөрийгөө болон бусдыг зөв шударга үнэлэх арга ухаанд сургахыг цаг үе биднээс шаардаж байгаа билээ.

Иймээс, суралцагчдын идэвх оролцоо, хамтран суралцах үйлийг дэмжих, семинарын хичээлд санаачилгатай, бүтээлч сэтгэлгээгээр хандах хандлагыг төлөвшүүлэх зорилгоор “Үйл явцын рубрикийн үнэлгээг” боловсруулан, туршлаа.

“Ихэнх рубрик тухайн суралцагч тодорхой оноо буюу дүнг авахын тулд чанарын түвшингийн нөхцөлийг тохиролцсон байдаг. Түвшинг бүрдүүлж байгаа бүлэг үзүүлэлт, шалгуур зүйлсийг жишиг (бенчмарк) гэж нэрлэдэг.” (Нэнси П. Галлаван, 2009, х.182)

Хүснэгт 1

Нэнси П. Галлаваны боловсруулсан рубрикийн загвар

Бенчмарк	Дээд түвшин		Дунд түвшин		Доод түвшин	
	3	21-30 оноо	2	11-20 оноо	1	0-10 оноо
1						
2						

Эх сурвалж: Нэнси П. Галлаван, 2009, х.183

Туршилт судалгаа I.

Семинарын хичээлийн хүрээнд суралцагчдын идэвх оролцоог дэмжих, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийг үнэлэх зорилгоор дээрх загварыг үндэслэн 10 шалгуур, 3 түвшний хэмжээс бүхий рубрик боловсруулан, туршин хэрэгжүүллээ.

Тухайлбал,

Мэдлэг

- Семинарын хичээлийг агуулгыг судалж /маш сайн, судалсан/
- Ухагдахуун ойлголт, агуулгын тайлбар /бүтээлч оновчтой, сайн, дунд зэрэг/

Чадвар

- Эшлэл зүүлт, номзүйг жагсаалтыг зөв хийсэн /4-өөс доошгүй, 3-аас доошгүй, 3 ба түүнээс доош/
- Илтгэх ур чадвар /үлгэр жишээч, сайн, анхаарах/
- Бэлтгэж ашигласан хэрэглэгдэхүүн үг, үсгийн алдаагүй

Хандлага

- Бусдын анхаарал, сонирхлыг татах, бусадтай харилцах ур чадвар /үлгэр жишээч, сайн, анхаарах/
- Хамтран ажиллах, багаар ажиллах байдал /үлгэр жишээч, сайн, анхаарах/
- Семинарын бэлтгэлд багшийн зөвлөгөө авсан эсэх /цагаасаа өмнө, цагтаа авсан, аваагүй/
- Бусдын санаа бодлыг сонсох, хуваалцах чадвар /үлгэр жишээч, сайн, анхаарах/
- Бэлтгэсэн хугацаа /цагаасаа өмнө, цаг хугацаанд нь, цаг хугацаа хожимдсон/ зэрэг үзүүлэлтийг хангалттай сайн /21-30 оноо/, хангалттай /11-20 оноо/, дунд /0-10 оноо/ гэж түвшингээр нь оноожууллаа.

Хүснэгт 2

Туршилтын үр дүн

Үзүүлэлт	Туршилтын өмнө /25/		Туршилтын явц			
	Оюутны тоо	Хувь	Хангалттай сайн /21-30 оноо/		Хангалттай /11-20 оноо/	
			Оюутны тоо	Хувь	Оюутны тоо	Хувь
Агуулгыг судалж ойлгосон	2	8%	5	21.7%	13	56.5%
Ухагдахууныг ойлгож, тайлбарласан	4	8.1 %	6	24%	12	52.1%
Эшлэл зүүлт, номзүйн жагсаалт хийсэн эсэх	10	40%	7	28%	13	56.5%
Илтгэх ур чадвар	7	28%	9	36%	12	52.1%
Хэрэглэгдэхүүний үг, үсгийн алдаа	5	20%	10	40%	12	52.1%
Бусдын анхаарал, сонирхлыг татах, бусадтай харилцах	3	12%	6	24%	10	40%
Хамтран ажиллах, багаар ажиллах	3	12%	7	28%	15	65.2%
Семинарын бэлтгэлд багшийн зөвлөгөөг авсан эсэх	5	20%	9	36%	12	52.1%
Бусдын санаа бодлыг сонсох, хуваалцах чадвар	4	16%	8	32%	11	44%
Бэлтгэсэн хугацаа	3	12%	10	40%	13	56.5%

Семинар хичээлийн гүйцэтгэлийг үнэлэхэд, ангийн нийт оюутны 4 нь хангалттай сайн түвшинд, 17 нь хангалттай түвшинд, 1 нь дунд түвшинд үнэлэгдэж, тухайн хичээлийн агуулгыг судалж сайн ойлгосон 56.5%, ухагдахууныг сайн тайлбарласан 52.1%, ишлэл зүүлт, номын жагсаалтыг зөв хийж, 3-ээс доошгүй бүтээл ашигласан 56.5%, илтгэх ур чадвар сайн 52.1%, бэлтгэж ашигласан хэрэглэгдэхүүн үг, үсгийн алдаагүй 52.1%, бусдын анхаарал сонирхлыг татах, бусадтай харилцах ур чадвар үлгэр сайн 40%, багаар хамтран ажиллах байдал сайн 65.2%, багшаас зөвлөгөөг цагтаа авсан 52.1%, бусдын санаа бодлыг сонсох, хуваалцах чадвар сайн 44%, цагтаа бэлтгэсэн 56.5%- тай байна.

Хүснэгт 3

Туршилтын үр дүнг эрэмбэлвэл

Багаар хамтран ажиллах байдал сайн	65.2%
Тухайн хичээлийн агуулгыг судалж сайн ойлгосон	56.5%
Ишлэл зүүлт, номын жагсаалтыг зөв хийж, 3-аас доошгүй бүтээл ашигласан	56.5%
Семинарын хичээлийн бие даалтыг цаг хугацаанд хийж гүйцэтгэсэн.	56.5%
Нэр томьёо, ухагдахууныг сайн ойлгож, тайлбарласан	52,1%
Илтгэх ур чадвар	52.1%
Семинарын бэлтгэлд багшийн зөвлөгөөг авсан эсэх	52.1%

Дээрх үзүүлэлтүүд 50%-аас дээш хувьтай байгаа нь туршилт үр дүнтэй болж, суралцагчдын семинарын хичээлд хандах хандлага, төлөвшил, идэвх оролцоо, манлайлалд эергээр нөлөөлсөн нь тодорхой харагдаж байна.

Туршилт судалгаа II

Суралцагчид рубрикийн үнэлгээний зорилго, давуу талыг ойлгож, тавигдсан шалгуурыг хэрэгжүүлэхийг хичээдэг болсон. Иймээс, багш рубрикийн үнэлгээний цар хүрээг өргөтгөх шаардлагатай гэж үзээд, үйл явцын рубрикийг багшийн үнэлгээнээс гадна өөрийн үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээний хэлбэрээр боловсруулж, туршин хэрэгжүүллээ.

Хүснэгт 4
Туршилт судалгааны үр дүн

Үзүүлэлт	Багшийн үнэлгээ			Өөрийн үнэлгээ			Хөндлөнгийн үнэлгээ		
	Хангалттай сайн /3/ 21-30 (хувь)	Хангалттай /2/ 11-20 (хувь)	Дунд /1/ 0-10 (хувь)	Хангалттай сайн /3/ (хувь)	Хангалттай /2/ (хувь)	Дунд /1/ (хувь)	Хангалттай сайн /3/ (хувь)	Хангалттай /2/ (хувь)	Дунд /1/ (хувь)
Агуулгыг судалж ойлгосон	21.7	56.5	21.8	59	31.8	9.2	30.4	56.5	13.1
Ухагдахууныг ойлгож, тайлбарласан	24	52.1	23.9	54.5	36.3	9.2	30.4	60.8	8.8
Эшлэл зүүлт, номзүйн жагсаалт хийсэн эсэх	28	56.5	15.5	63.6	27.2	9.2	52.1	34.7	13.2
Илтгэх ур чадвар	36	52.1	11.9	54.5	27.2	18.3	34.7	43.4	21.9
Хэрэглэгдэхүүний үг, үсгийн алдаа	40	52.1	7.9	27.2	50	22.8	30.4	47.8	21.8
Бусдын анхаарал, сонирхлыг татах, бусадтай харилцах	24	40	36	40.9	50	9.2	43.4	43.4	13.2
Хамтран ажиллах, багаар ажиллах	28	65.2	6.8	81.8	13.7	4.5	52.1	34.7	13.2
Семинарын бэлтгэлд багшийн зөвлөгөөг авсан эсэх /багийн гишүүдийн оролцоо/	36	52.1	11.9	68.5	27.2	4.5	43.4	52.1	4.5
Бусдын санаа бодлыг сонсох, хуваалцах чадвар	32	44	24	50	40.9	9.2	26	56.5	17.5
Бэлтгэсэн хугацаа /хичээлийн үр дүн/	40	56.5	3.5	81.8	18.2	0	52.1	43.4	4.5

Хүснэгт 5
Туршилтын үр дүнг, үнэлгээний үндсэн гурван объектоор эрэмбэлэхэд

Үнэлгээний объект		Хангалттай Сайн (хувь)	Хангалттай (хувь)	Дунд (хувь)
Төлөвшил	Бие хүний эрхэм чанарыг үнэлнэ. Хичээл зүтгэл, өөрийгөө дайчлах, хичээнгүй нямбай, хариуцлагатай, бие даасан, бусдыг хүндлэх хайрлах, хамтач, тусч, хөдөлмөрч, эелдэг даруу, үнэнч шударга, ухаалаг шийдвэр гаргах зэрэг зан үйл (Ичинхорлоо, 2011.х.153)	34	56.5	9.6
Чадвар	Унших, найруулан бичих, тэмдэглэл хийх, тодорхойлолт өгөх, санаагаа ойлгомжтой ярих, нотлох, ажиглах, харьцуулан жиших Задлан шинжлэх, ангилан бүлэглэх, ерөнхийлөн дүгнэх гэх мэт үйлдлийг бие даан ухамсартай хийх	32.6	53.5	13.8
Мэдлэг	Ухагдахуун, тодорхойлолт, томъёо, дүрэм Зарчим, онол, хууль, зүй тогтол гэх мэт	22.8	54.3	22.9

Суралцагчдын төлөвшил буюу семинарын хичээлд хандах хандлага, идэвх оролцоо, бусадтай харилцах, хамтран харилцах чадварын түвшинд нэлээд ахиц өөрчлөлт гарч, хангалттай сайн, хангалттай үзүүлэлтийн эзлэх хувиар эхэнд жагссан байгаа нь бидний боловсруулан туршсан “рубрик” үр дүнтэйг нотолж байна.

Туршилтын үр дүнгээс харахад багшийн болон хөндлөнгийн үнэлгээ ойролцоо хувьтай, өөрийн үнэлгээ нь харьцангуй илүү хувьтай

харагдаж байгаа хэдий ч, суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагын хэмжээс, гүйцэтгэл нь гурван үнэлгээний дунджаар дүгнэгдсэн учир бодитой гэж үзэх үндэслэлтэй юм. Нөгөө талаар, суралцагчид өөрийгөө үнэлэх, бусдыг үнэлэх аргазүйд суралцах давуу талтай болох нь судалгаанаас харагдаж байна.

Судалгааны үр дүнг туршилтын өмнө ба туршилтын дараа үеийн “хангалттай” гэсэн түвшний өсөлтийн дунджийг харвал,

Хүснэгт 6 Үр дүнгийн харьцуулалт

Үнэлгээний объект	Туршилтын өмнө (хувь)	Туршилтын дараа (хувь)	Өсөлтийн дундаж үзүүлэлт (хувь)
Мэдлэг	16.1	54.3	43.2
Чадвар	29.3	53.5	56.0
Төлөвшил	14.4	56.5	42.6

Өсөлтийн дундаж үзүүлэлтээс харахад, рубрикээр үнэлэх шалгуурын гүйцэтгэлийн үр дүн мэдлэг, чадвар, төлөвшил гэсэн объектын “хангалттай” түвшинд 27.1-28.2 хувиар ахисан нь “рубрикийн үнэлгээ”-ний нэгэн төрлийг туршсан судалгааны зорилго амжилттай хэрэгжсэнийг баталж байна.

Дүгнэлт

1. Бидний боловсруулан туршсан “рубрикийн үнэлгээ” суралцагчдын семинарын хичээлд хандах хандлагад эергээр нөлөөлж, идэвх сонирхлыг өрнүүлэхэд чухал үр дүн үзүүлсэн нь төлөвшил хандлага, идэвх оролцоог илэрхийлсэн шалгуурт харгалзах “хангалттай түвшний үнэлгээ” 28.2 хувиар өссөн дундаж үзүүлэлтээс харагдаж байна.
2. Туршилтын явцад, суралцагчид өөрийгөө үнэлэх, бусдыг үнэлэх рубрик боловсруулан, үнэлгээний хэлбэрийг өргөтгөснөөр багаар хамтран ажиллах, бусдыг сонсох, бусадтай зөв харилцах, өөрийгөө зөв илэрхийлэх, өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг шударга хийх арга барил эзэмшүүлэхэд чухал нөлөө үзүүллээ.
3. Үнэлгээний шалгуур, хэмжээс зэргийг суралцагчдад урьдчилан танилцуулдаг учир тэдний идэвх сонирхлыг өдөөх, оролцоог дэмжих, суралцах үйлийг төлөвлөх, хүссэн үр дүнд хүрэх боломжийг бүрдүүлдэг нь судалгаагаар нотлогдлоо.

Ашигласан материал

- Боловсролын үнэлгээ. (2016). ОУЭШХ-ын эмхэтгэл. Улаанбаатар
Ичинхорлоо, Ш. (2011). *Сургалт*. Улаанбаатар
Ичинхорлоо, Ш. (2011). *Сурах арга*. Улаанбаатар
Нэнси П, Галлаван. (2009). *Гүйцэтгэлд суурилсан үнэлгээ боловсруулах нь*. Улаанбаатар
Пүрэвдорж, Ч. (2013). *Багшлахуйн менежмент*. Улаанбаатар
Эрдэнэцэцэг, С., ба бус. (2011). *Багш боловсролын үндэс*. Улаанбаатар